



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн арван тавдугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/117/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.open.audit.mn

Архангай аймаг

2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Грут финанс Аудит ХХК-ийн

Гүйцэтгэх захирал Б.Бямбадорж

Утас: 77721628

Цахим хаяг: Byambadorj@growthfinance.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026. 02. 24 № 48
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН
СУМЫН ХҮҮХДИЙН 15 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.НЯМХҮҮ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Хүүхдийн 15 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 15 дугаар цэцэрлэг нь 11,982.6 мянган төгрөгийн бараа материал, 5,960.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсныг санхүүгийн тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн хүрээнд үндсэн үйл ажиллагааны 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 794,556.5 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, гүйцэтгэлээр 722,243.2 мянган төгрөг зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 үндсэн зорилтын хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	185,507,763.75	146,639,767.98
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	108,660,064.75	72,292,828.98
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	108,660,064.75	72,292,828.98
3121	Төгрөг	108,660,064.75	72,292,828.98
31211	Төрийн сангийн харилцах	108,660,064.75	72,292,828.98
35	БАРАА МАТЕРИАЛ	76,847,699.00	74,346,939.00
351	Түүхий эд материал	790,850.00	790,850.00
3513	Эм боох материал	790,850.00	790,850.00
354	Хангамжийн материал	76,056,849.00	73,556,089.00
3541	Бичиг хэргийн материал	1,154,400.00	1,030,400.00
3542	Аж ахуйн материал	74,902,449.00	72,525,689.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,683,048,152.14	1,650,518,913.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,683,048,152.14	1,650,518,913.04
392	Биет хөрөнгө	1,659,048,152.14	1,626,518,913.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,713,058,206.00	1,713,058,206.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(118,962,375.50)	(147,513,345.62)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	75,808,343.00	76,808,343.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,387,209.06)	(40,168,082.50)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,579,627.00	43,183,627.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(15,296,939.30)	(19,153,334.84)
39217	Ном	248,500.00	303,500.00
393	Биет бус хөрөнгө	24,000,000.00	2,000,000.00
39301	Програм хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(600,000.00)	(600,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	24,000,000.00	24,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,868,555,915.89	1,797,158,681.02
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,868,555,915.89	1,797,158,681.02
51	Засгийн газрын хувь оролцоо	1,868,555,915.89	1,797,158,681.02
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	1,868,555,915.89	1,797,158,681.02
5121	Өмнөх үеийн үр дүн	1,868,555,915.89	1,868,555,915.89
5122	Тайлант үеийн үр дүн		(71,397,234.87)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,868,555,915.89	1,797,158,681.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	682,779,830.00	717,501,360.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,413,530.00	18,117,560.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,413,530.00	18,117,560.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000.00	175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	175,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	8,962,030.00	5,960,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	381,500.00	11,982,560.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	673,366,300.00	699,383,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	609,728,600.00	651,384,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	609,728,600.00	651,384,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,637,700.00	47,999,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,637,700.00	47,999,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	666,905,065.02	788,898,594.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	666,905,065.02	788,898,594.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	644,551,655.95	769,640,342.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	446,298,689.24	543,272,656.42
210101	Үндсэн цалин	335,612,728.24	374,629,769.42
210102	Нэмэгдэл	99,249,411.00	130,525,887.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		12,985,000.00
210104	Урамшуулал	11,436,550.00	25,132,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,872,341.87	67,060,939.35
210201	Тэтгэврийн даатгал	38,276,672.42	45,916,831.40
210202	Тэтгэмжийн даатгал	4,636,514.96	5,420,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,242,357.88	2,698,562.24
210204	Ажилгүйдлийн даатгал	2,143,356.33	2,605,048.81
210205	Эрүүл мэндийн даатгал	8,573,440.28	10,419,996.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,208,790.93	29,316,448.10
210301	Гэрэл, цахилгаан	10,026,478.00	12,111,241.00
210302	Түлш, халаалт	12,362,500.00	11,224,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,819,812.93	5,981,207.10
2104	Хангамж, бараа материалын зардал	418,200.00	13,689,760.00
210401	Бичиг хэрэг	418,200.00	1,707,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		11,982,560.00
2105	Нормативт зардал	50,516,080.00	50,502,140.00
210502	Хоол, хүнс	50,516,080.00	50,502,140.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,976,000.00	4,925,000.00
210604	Урсгал засвар	6,976,000.00	4,925,000.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	990,000.00	2,063,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	2,063,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,271,553.91	58,809,699.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,940,063.00	11,047,660.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,032,400.00	4,573,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	41,299,090.91	43,188,239.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,353,409.07	19,258,251.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,066,900.00	5,575,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,066,900.00	5,575,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,286,509.07	13,682,851.90
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,286,509.07	13,682,851.90
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн арвантавдугаар цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	15,874,764.98	(71,397,234.87)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	15,874,764.98	(71,397,234.87)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	673,436,300.00	699,558,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,000.00	175,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	70,000.00	175,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000.00	175,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	175,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	673,366,300.00	699,383,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	609,728,600.00	651,384,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	609,728,600.00	651,384,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	63,637,700.00	47,999,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	63,637,700.00	47,999,300.00
II	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	648,748,711.11	731,227,035.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	648,748,711.11	731,227,035.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	626,395,302.04	711,968,783.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	446,298,688.24	543,272,656.42
210101	Үндсэн цалин	335,612,727.24	374,629,769.42
210102	Нэмэгдэл	99,249,411.00	130,525,887.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		12,985,000.00
210104	Урамшуулал	11,436,550.00	25,132,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,872,342.87	67,060,939.35
210201	Тэтгэврийн даатгал	38,276,673.42	45,916,831.40
210202	Тэтгэмжийн даатгал	4,636,514.96	5,420,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,242,357.88	2,698,562.24
210204	Ажилгүйдлийн даатгал	2,143,356.33	2,605,048.81
210205	Эрүүл мэндийн даатгал	8,573,440.28	10,419,996.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,208,790.93	29,316,448.10
210301	Гэрэл, цахилгаан	10,026,478.00	12,111,241.00
210302	Түлш, халаалт	12,362,500.00	11,224,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,819,812.93	5,981,207.10
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	50,516,080.00	50,502,140.00
210502	Хоол, хүнс	50,516,080.00	50,502,140.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,142,400.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	23,142,400.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,286,200.00	2,063,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,286,200.00	2,063,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,070,800.00	14,752,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,026,200.00	9,658,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,044,600.00	5,094,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,353,409.07	19,258,251.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,066,900.00	5,575,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,066,900.00	5,575,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,286,509.07	13,682,851.90
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	13,286,509.07	13,682,851.90

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн арвантавдугаар цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	24,687,588.89	(31,668,235.77)
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,305,000.00	4,699,000.00
	Дотоод эх үүсвэрээр	2,305,000.00	4,699,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,305,000.00	4,699,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,305,000.00)	(4,699,000.00)
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	22,382,588.89	(36,367,235.77)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	86,277,475.86	108,660,064.75
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	108,660,064.75	72,292,828.98

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл			1,852,681,150.91	1,852,681,150.91
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Тайлант үеийн үр дүн			15,874,764.98	15,874,764.98
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл			1,868,555,915.89	1,868,555,915.89
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Тайлант үеийн үр дүн	-	-	(71,397,234.87)	(71,397,234.87)
2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	-	1,797,158,681.02	1,797,158,681.02

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Бүртгэлийн дансны код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2	794,556,500.00	722,243,183.87	72,313,316.13	90.9
УРСГАЛ ЗАРДАЛ	21	794,556,500.00	722,243,183.87	72,313,316.13	90.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	210	788,981,100.00	716,667,783.87	72,313,316.13	90.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2101	583,405,900.00	543,272,656.42	40,133,243.58	93.1
Үндсэн цалин	210101	397,000,800.00	74,629,769.42	22,371,030.58	94.4
Нэмэгдэл	210102	167,879,700.00	30,525,887.00	37,353,813.00	77.8
Унаа хоолны хөнгөлөлт	210103		12,985,000.00	(12,985,000.00)	
Урамшуулал	210104	18,525,400.00	25,132,000.00	(6,606,600.00)	135.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2102	72,550,600.00	67,060,939.35	5,489,660.65	92.4
Тэтгэврийн даатгал	210201	49,214,400.00	45,916,831.40	3,297,568.60	93.3
Тэтгэмжийн даатгал	210202	5,834,000.00	5,420,500.00	413,500.00	92.9
ҮОМШӨ-ний даатгал	210203	2,917,000.00	2,698,562.24	218,437.76	92.5
Ажилгүйдлийн даатгал	210204	2,917,000.00	2,605,048.81	311,951.19	89.3
Эрүүл мэндийн даатгал	210205	11,668,200.00	10,419,996.90	1,248,203.10	89.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2103	42,999,300.00	29,316,448.10	13,682,851.90	68.2
Гэрэл, цахилгаан	210301	18,386,400.00	12,111,241.00	6,275,159.00	65.9
Түлш, халаалт	210302	16,092,900.00	11,224,000.00	4,868,900.00	69.8
Цэвэр, бохир ус	210303	8,520,000.00	5,981,207.10	2,538,792.90	70.2
Хангамж, бараа материалын зардал	2104				
Нормативт зардал	2105	62,623,600.00	50,502,140.00	12,121,460.00	80.6
Хоол, хүнс	210502	62,623,600.00	50,502,140.00	12,121,460.00	80.6
Эд хогшил, урсгал засварын зардал	2106	5,000,000.00	5,000,000.00		100.0
Урсгал засвар	210604	5,000,000.00	5,000,000.00		100.0
Томилолт, зочны зардал	2107				
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2108	2,757,400.00	2,063,700.00	693,700.00	74.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210806	2,757,400.00	2,063,700.00	693,700.00	74.8
Бараа үйлчилгээний бусад зардал	2109	19,644,300.00	19,451,900.00	192,400.00	99.0
Бараа үйлчилгээний бусад зардал	210901	14,549,900.00	14,357,500.00	192,400.00	98.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210902	5,094,400.00	5,094,400.00		100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	213	5,575,400.00	5,575,400.00		100.0
Бусад урсгал шилжүүлэг	2132	5,575,400.00	5,575,400.00		100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	213209	5,575,400.00	5,575,400.00		100.0
Орон нутгийн төсвийн ерөнхийлэн захирагчдад олгох	2134				
Төвлөрүүлэх шилжүүлэг	213403				
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22				
Дотоод эх үүсвэрээр ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1	794,556,500.00	685,875,948.10	108,680,551.90	86.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	131	652,099,400.00	651,384,500.00	714,900.00	99.9
Улсын төсвөөс санхүүжих	131001	652,099,400.00	651,384,500.00	714,900.00	99.9
Нэмэлт санхүүжилтийн орлого	1311				
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	132	47,999,300.00	34,316,448.10	13,682,851.90	71.5

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн арвантавдугаар цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Орон нутгийн төсвөөс	132001	47,999,300.00	34,316,448.10	13,682,851.90	71.5
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	120004	94,457,800.00	175,000.00	94,282,800.00	0.2
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1200042	175,000.00	175,000.00		100.0
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1200043	94,282,800.00		94,282,800.00	0.0
БУСАД ЭХ ҮҮСВЭР	124				
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31		108,660,064.75		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31		72,292,828.98		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1				
БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	1	1		100.0
Төсвийн байгууллага	3	1	1		100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	5	23	23		100.0
Удирдах ажилтан	6	1	1		100.0
Гүйцэтгэх ажилтан	7	7	7		100.0
Үйлчлэх ажилтан	8	15	15		100.0
СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	14	1	1		100
Төрийн өмчит СӨБ байгууллага	15	100	100		100

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 967.4 мянган төгрөгийн 1 алдаа илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

- "35420 Аж ахуйн материал" дансны кредит дүн нь бараа материалын тайлангийн зарлагын дүнгээс 967.4 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэнээс эцсийн үлдэгдэл нь мөн дүнгээр зөрүүтэй илэрхийлэгдсэн.

Аудитаар залруулаагүй 4,002.1 мянган төгрөгийн зөрчил илэрч, 4,002.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 4,002.1 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 8,986.2 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1. "Балансын урамшуулал олгох тухай" тус Архангай аймгийн Боловсролын газрын даргын 2025.09.03-ны өдрийн А/38 дугаар тушаал, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025.09.04-ны Б/30 дугаар тушаалаар 2024 оны санхүүгийн тайланд өөрчлөлтгүй дүгнэлт авсан гэсэн үндэслэлээр нягтлан бодогчид 1,559.0 мянган төгрөгийн, няравт 1,105.0 мянган төгрөг нийт "балансын урамшуулал" 2,664.0 мянган "улирлын үр дүнгийн урамшуулал"-тай давхардуулан олгосон нь хууль, журамд нийцэхгүй байна.

Энэ нь "Төрийн хэмнэлтийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно": 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Төрийн албаны тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.Онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн болон бусад нөхцөл, шаардлагыг хангасан төрийн албан хаагчийг дараах хэлбэрээр шагнаж, урамшуулна: 51.1.4 "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

3.1.2. Багш ажилтнуудын гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг олгохдоо зөвхөн "Хувь хүний орлогын албан татвар" 10 хувь 557.5 мянган төгрөг суутган 5,017.8 мянган төгрөгийг 22 ажилтанд олгохдоо суутган буюу ногдуулан төлөх 1,338.1 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тайлагнаагүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дугаар зүйлийн 19.1 "Даатгуулагч, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнд дараах цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг хамааруулна": 19.1.1 "Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.5 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэг, 111, 112, 113, 114, 115, 116, 117 дугаар зүйлд тус тус заасан цалин хөлс, олговор" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл
(мянган төгрөгөөр)

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн арвантавдугаар цэцэрлэгийн 2025 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
БМ-ын алдаатай тайлагнал	1	967.4			1	967.4	1	967.4		
Нийт дүн	1	967.4	-	-	1	967.4	1	967.4	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл
(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Балансын урамшуулал олгосон	1	2,664.0			1	2,664.0				
НДШ суутган буюу ногдуулаагүй.	1	1,338.1			1	1,338.1				
Дүн	2	4,002.1	-	-	2	4,002.1	-	-	-	-